

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

**УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ
ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**



**ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА УДААШРАЛТАЙ БАЙГААГААС
ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА ЖИЛ БҮР СУНГАГДАХ МАГАДЛАЛТАЙ БАЙНА**

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар

Захирал *Б.Баттуяа*

Аудитын
менежер *Г.Гүнжидмаа*

Аудитор *Ш.Энхтайван*

Шинжээч *М.Доржмаа*
Ж.Оюунтуяа

*Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 261885, 263755, 261805
дугаарын утас, 323266
дугаарын факсаар харилцана уу*

ХАЯГ:

*Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс*

Агуулга 2

Товчилсон үгийн жагсаалт 3

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
стандартын талаарх мэдэгдэл** 4

Ерөнхий зүйл 5

Бүлэг 1. Төсөл хэрэгжүүлэгч байгуулага, удирдах хороо, нэгжийн үйл ажиллагаа

Төслийн удирдах хороог байгуулахдаа хэлэлцээр
болон журмын заалтыг зөрчсөн байна 6

Төслийн удирдах хороо журамд заасан
хугацаанд хуралдаагүй байна 6

Төслийн нэгжийг байгуулахад журам зөрчигдсөн
байна 7

Төслийн удирдах хорооны баталсан төсвөөс
гадуур зардал санхүүжүүлжээ 7

Бүлэг 2 Төслийн хэрэгжилт, үр дүн

Төслөөс тодорхой үр дүн гарч эхлээгүй байна 9

Салбарын хөгжил, төрийн өмчийг удирдан
зохицуулах, чадавхийг сайжруулах чиглэлээр
явагдсан сургалтуудын үр дүн бага байна 12

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

ХАВСРАЛТ

Товчилсон үгийн жагсаалт

АМГ	Ашигт малтмалын газар
АХБ	Азийн хөгжлийн банк
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГЗТЗТХ	Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай хууль
ЗТБЗГ	Зээл тусламжийн бодлого зохицуулалтын газар
ЗТЭ	Зээлжих тусгай эрх
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
СЯ	Сангийн Яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УИХ	Улсын Их Хурал
УУДБХОДТ	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл
УУИБТТТ	Уул уурхайн институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл
УУЯ	Уул уурхайн яам
УУХҮГ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЦЭГ	Цөмийн энергийн газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх төслийн үйл ажиллагааны үр дүн, зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийж үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаа хэлэлцээрийн дагуу хэрэгжсэн эсэх
- Төслийг хэрэгжүүлснээр бодит үр дүн гарсан эсэх

Хамарсан хүрээ

Аудитад Сангийн яам, Уул уурхайн яам, Эрчим хүчний яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Төрийн өмчийн хороо, “Эрдэнэс МГЛ” ХХК, төсөл хэрэгжүүлэх нэгж болон холбогдох бусад байгууллага хамрагдлаа.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын дараах арга зүйг ашиглалаа. Үүнд:

- Холбогдох албан тушаалтантай ярилцаж, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судалгаа хийх, төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлэх
- Аудитын хөтөлбөр, арга зүй, горимын дагуу цуглуулсан баримт материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий зүйл

- 1.1 Улсын Их Хурал 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан Дэлхийн банкны 2,570.0 мянган зээлжих тусгай эрхийн буцалтгүй тусламж, 3,150.0 мянган зээлжих тусгай эрхийн зээлээр санхүүжүүлэх “Уул уурхайн институцийн чадавхийг бэхжүүлэх техник туслалцаа”-ны төслийн хэлэлцээрийг соёрхон баталжээ.
- 1.2 Төслийн зорилт нь “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн үйл ажиллагааг оролцуулан төрийн болон үйлдвэрлэлийн салбар, иргэний нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан уул уурхайн олборлох салбарын бодлого, санхүү, эрх зүйн зохицуулалт, институцийн бүтцийг бий болгоход чиглэгдсэн байна.
- 1.3 Төслийг хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын институцийн чадавхи бэхжиж, тус салбараас улсын төсөвт төвлөрөх хөрөнгө нэмэгдэх, татварын хяналт, хууль эрх зүйн орчин сайжирна гэж үзэж байгаа ажээ.
- 1.4 Төслийн хугацаанд нийт 2,896.4 мянган ам.долларын буцалтгүй тусламж, 2,732.2 мянган ам.долларын зээл, нийт 5,628.6 мянган ам.долларын санхүүжилтийг ОУХА-аас хүлээн авсан байна.
- 1.5 Энэ нь нийт санхүүжилтийн 60.5 хувь бөгөөд буцалтгүй тусламжийн 69.2 хувь, зээлийн 53.4 хувийг ашигласан байна. Хэлэлцээрийн дагуу 2012 онд төслийн хугацаа дууссан хэдий ч төслийн үйл ажиллагааны гүйцэтгэл хангалтгүй байгаагаас ОУХА-аас олгосон зөвшөөрлийн дагуу 2013 он дуустал төслийн хугацааг сунгасан байна.

Бүлэг 1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, удирдах хороо, нэгжийн үйл ажиллагаа

Төслийн удирдах хороог байгуулахдаа хэлэлцээр болон журмын заалтыг зөрчсөн байна

- 2.1 Хэлэлцээрт төсөл хэрэгжүүлэх нэгжийг бодлогын удирдамжаар хангах, ерөнхий хяналтыг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороог ажиллуулахаар тусгажээ.
- 2.2 Удирдах хороог Сангийн яамны ТНБД ахлан, бүрэлдэхүүнд нь Сангийн яам, ЗГХЭГ, ҮХЯ, БОЯ, АМГТХЭГ, ТЕГ, ТӨХ, “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн төлөөлөл, төслийн менежер орохоор заасан байна.
- 2.3 Сангийн сайдын 2009 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн тушаалаар байгуулсан Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнд ЗГХЭГ-ын төлөөлөл, төслийн зохицуулагч оролцоогүй бөгөөд 2009 оны 59 дүгээр тушаалаар БОАЖЯ-ны /хуучнаар/ төлөөллийг хассан нь хэлэлцээр болон “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 8.2-ын “...ТУХ-ны бүрэлдэхүүнд тухайн төслийн удирдагч болон ... гадаад зээлийн асуудал хариуцсан нэгжийн тухайн зээл хариуцсан мэргэжилтэнг оруулна” гэсэн заалтыг зөрчжээ.

Төслийн удирдах хороо журамд заасан хугацаанд хуралдаагүй байна

- 2.4 Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журмаар төслийн удирдах хороо улиралд нэгээс доошгүй удаа, шаардлагатай тохиолдол гарсан тухай бүрт хуралдах үүрэгтэй байна.
- 2.5 Хурлын тэмдэглэлээс үзэхэд 2010 онд 2, 2012 онд 3 удаа хуралдсан байна. Энэ нь төслийг хэрэгжүүлэхэд тулгарсан асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, төслийн нэгжийг заавар, зөвлөмж, удирдамжаар хангаж ажиллахад хангалтгүй юм.
- 2.6 Журмын хэрэгжилт хангалтгүй, төслийн үйл ажиллагааны явц удаашралтай байхад Төслийн удирдах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн тогтоолоор баталсан журмын дагуу хорооны гишүүдийн урамшуулалд 2009-2011 онд нийт 4,600.0 ам.долларыг зарцуулсан байна.
- 2.7 Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 15.1.6-д заасан "албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төслийн нэгжийг байгуулахад журам зөрчигдсөн байна

- 2.8 Санхүүжилтийн хэлэлцээрт зааснаар төсөл хэрэгжүүлэгч нэгжийг 3 ажилтны орон тоотой байгуулах ба Сангийн яам бусад ажилтнуудыг томилох үүрэгтэй байна.
- 2.9 Сангийн яамнаас сонгон шалгаруулалт явуулж төслийн нэгжийг менежер, худалдан авалт хариуцсан ажилтан, нягтлан бодогчийн орон тоотой байгуулжээ. Гэтэл удирдах хорооны 2009 оны 6 дугаар тогтоолоор 3 орон тоо, 2012 онд 1 орон тоо нэмсэн нь журмын 6.1-ийн “Хэлэлцээрт төслийн нэгж байгуулах тухай тусгасан тохиолдолд түүний бүтэц, орон тоо, цалин, үйл ажиллагааны зардал зэргийг төсөл хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн гадаадын зээл тусламжийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар батална” гэж заасныг зөрчиж сайдын тушаалгүйгээр орон тоо нэмсэн байна.

Төслийн удирдах хорооны баталсан төсвөөс гадуур зардал санхүүжүүлжээ

- 2.10 Төслийн удирдах хорооны 2009 оны 6 дугаар тогтоолоор төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалин, үйл ажиллагааны зардлын жишиг, удирдах хорооны гишүүдийн урамшууллын тарифыг баталсан байна.

- 2.11 Төслийн удирдах хорооны 2009 оны 10 дугаар тогтоолоор баталсан харилцах дансдын үлдэгдэлд тооцсон орлогыг зарцуулах, тайлагнах журмын дагуу 40.2 сая төгрөгийн хүүгийн орлогыг дараах байдлаар зарцуулжээ.

№	Зардлын зүйл	Дүн /ам.доллар/	Дүн /мян.төг/
1	Баяр ёслолын арга хэмжээний зардал	4,826.42	6,940.3
2	Албан уулзалтын зардал	3,254.67	4,680.2
3	Эрүүл мэндийн шинжилгээний зардал	842.48	1,211.5
4	Хэвлэлийн зардал	1,084.07	1,558.9
5	Бусад зардал	3,499.08	5,031.6
6	Эд хогшил авах зардал	2,789.71	4,011.5
7	Бэлэг дурсгалын зардал	828.60	1,191.5
8	Сургалт семинарын зардал	1,955.65	2,812.2
	Нийт	19,080.68	27,437.7

/2013 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн Монголбанкны албан ханш 1437.98/

- 2.12 ТХН-ийн дотоод үйл ажиллагааны зардлыг хүснэгтээр харуулбал:

№	Зардлын зүйл	Дүн /ам.доллар/	Дүн /мян.төг/
1	Төслийн удирдах хорооны гишүүдийн урамшуулалд	4,652.05	6,689.6
2	Төслийн удирдах хорооны хурлын зардалд	308.25	443.3
3	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын урамшуулалд	3,550.0	5,104.8
4	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дотоод зардалд	19,080.68	27,437.6
5	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудад тэтгэмж	373.17	536.6
	Нийт	27,964.15	40,211.9

- 2.13 Төслийн ажилтнууд нь зөвлөхийн статустай, нийгмийн болон бусад шимтгэл хураамжаа өөрөө хариуцах ба хүлээн авагч талаас нийгмийн асуудлыг хариуцахаар гэрээнд тусгаагүй байхад ихээхэн хэмжээний

хөрөнгийг нийгмийн асуудлыг шийдвэрлэх, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулахад зарцуулсан байна.

Бүлэг 2. Төсийн хэрэгжилт, үр дүн

Төслөөс тодорхой үр дүн гарч эхлээгүй байна

3.1 Уул уурхайн салбарын дотоодын бодлогыг тодорхойлох Think-Thank төв болон баялгийн санг байгуулах, төрийн өмчит корпорацийн тогтолцоог бүрдүүлэх, салбарын хууль, дүрэм, журмыг шинэчлэн сайжруулах, хөрөнгө оруулалтын гэрээний загвар гаргах, мэдээлэл сурталчилгааны стратеги төлөвлөгөө боловсруулах, гарын авлага түгээх зэрэг ажлыг дараах бодлогын хүрээнд нэгтгэн хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Үүнд:

- Эдийн засгийн удирдах гол байгууллагууд;
- Орлого цуглуулах гол байгууллагууд;
- Олборлох салбарын гол байгууллагууд, гар аргаар олборлох уурхай, жижиг уурхайн удирдлагыг боловсронгуй болгох;
- “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн чадавхийг сайжруулах ;

Дээрх 4 бодлогын хүрээнд хэрэгжих 15 томоохон ажлаас дараах ажлууд бүрэн хэрэгжсэн байна.

- Гадаадын хөрөнгө оруулагч нарт зориулсан уул уурхайн салбарын гарын авлага боловсруулах,
- Ашигт малтмалын нөөцийн ангилал, стратегийн газрын FSU нөөцийн мэдээллийн JORC болон 43-101 нөөцийн мэдээлэлд хөрвүүлэх, салбарын мэдээлэл сурталчилгааны стратегийг боловсруулах,
- Олон улсын далайн боомтоор дамжуулан бүтээгдэхүүн экспортлох судалгааг боловсруулах,
- ОХУ болон БНХАУ-руу бүтээгдэхүүн экспортлох жишиг тээвэрлэлтийг Эрдэнэс МГЛ ХХК-иас зохион байгуулж энэ чиглэлээр мэдээлэл авахыг хүссэн албан байгууллага, хувь хүмүүст хүргэх зэрэг ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.2 Эдийн засгийн удирдах гол байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх бодлогын хүрээнд 4 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хэрэгжээгүй байна. Үүнд:

- Баялгийн сан буюу улсын хөрөнгө оруулалтын санг 2010 онд байгуулахаар төлөвлөсөн боловч Хүний хөгжлийн сан, Тогтворжилтын сангуудын үйл ажиллагааг явуулсны дараа эдгээр сангуудад суурилан байгуулах Улсын хөрөнгө оруулалтын сан буюу Баялгийн санг байгуулах ажил хойшлогдсон;
- Уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээний загварыг бэлэн болгож мөрдөх, тус салбарт төрийн өмчийн оролцооны талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж олон нийтэд мэдээлэх ажил ашигт малтмалын төрөл, орд газрын онцлог, нөхцөл байдлаас хамааран гэрээнд өөрчлөлт орно гэж үзсэн тул олон улсын хөрөнгө оруулалтын гэрээг орчуулан холбогдох газруудад тараасан, шинээр гэрээний загварыг бэлэн болгож мөрдөөгүй;
- Шинээр бодлогын баримт бичиг боловсруулахын оронд одоо үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит корпорацийн тогтолцоог бүрдүүлэх үлгэрчилсэн загварыг туршиж хөрөнгө оруулалт хэлбэрээр хэрэгжүүлэх саналын дагуу “Эрдэнэс МГЛ” ХХК дээр туршилт хэрэгжүүлснээс өөр баримт бичиг боловсруулаагүй;
- Эдийн засгийн болон уул уурхайн салбарын бодлогын асуудлыг тодорхойлох, дотоодын бодлогын ThinkTank-ийг бий болгох, төвийн үйл ажиллагаа, санхүүжилт, дүрмийн талаарх судалгаа хийлгэж “Монголын хөгжлийн нөөцийн хүрээлэн” нэртэйгээр бий болгож үйл ажиллагаа эхлүүлсэн боловч судлаачдын цалин болон үйл ажиллагаатай уялдаатайгаар зогссон. 2013 онд өөр хувилбараар энэхүү ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

3.3 Мөн орлого цуглуулах гол байгууллагуудын үр ашгийг дээшлүүлэх бодлогын хүрээнд 3 арга хэмжээ хэрэгжүүлэхээс “Татварын хуульд уул уурхайн орлогын тухай дагалдах журам, заавар”-уудыг боловсруулах ажил хэрэгжээгүй байна.

3.4 “Гар аргаар олборлох уурхай, жижиг уурхайн удирдлагыг боловсронгуй болгох” дараах 6 төрлийн дүрэм, журмыг сайжруулах, шинээр боловсруулж нийтэд мөрдлөг болгох, хяналт шалгалт, мониторинг хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Уул уурхайн кадастр;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох процедурыг хялбарчилж, зарцуулах хугацааг багасгах;
- Уул уурхайн компанийн тайлагнах шаардлага,
- Салбарын ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зохицуулалт хийх;
- Нийгэм эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ нийгмийн сөрөг нөлөөллийг арилгах, тухайлбал шилжүүлэн суурьшуулах болон нөхөн олговор олгох,
- Уурхайн хаалт болон хаалтын дараах үеийн зохицуулалт,

3.5 Дээрх ажлууд хэрэгжээгүй нь төрийн зарим байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй, ажил үүрэг давхарсан зэрэг шалтгаантай холбоотой байна. Тухайлбал;

- УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос геологийн мэдээллийг олон нийтэд онлайн хэлбэрээр мэдээлэх үйл ажиллагааг зогсоож програмын эх кодыг Ашигт малтмалын газар өгөх боломжгүй болсон;
- Төслийн хүрээнд хийгдэх байсан уул уурхайн компанийн тайлагнах шаардлагын дүрэм журмыг Ашигт малтмалын газар боловсруулж эхэлсэн;
- Уул уурхайн тусгай зөвшөөрөл олголтыг зогсоосон, ашигт малтмалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байгаа;
- Уурхайн хаалт болон хаалтын дараах үеийн зохицуулалтын ажлын ТЭЗҮ хүлээн авах дүрмийг боловсруулсан боловч манай орны нөхцөлд нийцэхгүй гэж үзсэн байна.

3.6 Төслийн хүрээнд “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн үйл ажиллагааг зохих хууль эрх зүйн бүтэц болон корпорацийн дүрмийн дагуу тайлагнадаг систем бий болгох, байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай, удирдлага, зохион байгуулалт, засаглалын талаарх сургалтуудыг явуулахаар төлөвлөжээ.

3.7 Үүний дагуу компаний зорилго, алсын хараа, үүрэг хариуцлага, удирдлагын бүтэц, менежмент, богино хугацааны зорилтууд, “Эрдэнэс МГЛ”, “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн өмчлөлийн хувьд санхүүгийн төлөвлөгөө, гол ашигт малтмалын зах зээлийн үнэ цэн, санхүүжилтийн арга замууд, хүүгийн өсөлт зэргийг тодорхойлсон байна.

3.8 “Эрдэнэс МГЛ” ХХК-ийг олон улсын жишгийн дагуу төрийн өмчит үйлдвэрлэлийн компаний засаглалын дагуу хөгжүүлэх ажил төлөвлөгдсөн боловч тусгайлсан дүрэм болон удирдах зөвлөлийн бүтэц, Хүний хөгжлийн санг тус компаний үйл ажиллагаатай уялдуулсан нь хийгдэх ажлуудад өөрчлөлт орох, хойшлогдох шалтгаан болсон байна.

- 3.9 Төрийн өмчит компаний засаглалын кодекс боловсруулан олон улсын шилдэг жишгийн дагуу ил тод байдлыг хангах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлэх журам боловсруулах, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний тайлан болон тендерийн баримт бичиг боловсруулж Дэлхийн банкнаас зөвшөөрөл авахаар 2013 оны 2 дугаар сарын 2-ны өдөр хүргүүлснээс өөр ажил хийгдээгүй байна.
- 3.10 “Эрдэнэс МГЛ” ХХК-иас гадна уул уурхайн салбарын үйл ажиллагаанд оролцогч яамд, АМГ, ГТГ, МХЕГ, ЦЭГ, ТЕГ, ГЕГ зэрэг байгууллагуудын ажил үүрэг, харилцан уялдааг судалж зөвлөмж гаргах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.
- 3.11 Тухайлбал: Уул уурхайн яамны үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдэх ажлуудаас дараах 2 арга хэмжээг 2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

- Нүүрсний бодлого, нүүрсний ангиллыг боловсруулах зөвлөхийн үйлчилгээ, сургалт
- Уламжлалт бус аргаар олборлох хий, газрын тосны эх үүсвэрүүдийг ашиглах бодлого боловсруулах, эрх зүйн орчны судалгаа

Харин дор дурдсан ажлыг эхлэх хугацаа тодорхойгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

- Төмрийн хүдрийн бодлого, төмрийн хүдрийн ангиллыг боловсруулах, зөвлөхийн үйлчилгээ сургалт
- Уламжлалт бус аргаар олборлох хий, газрын тосны эх үүсвэрүүдийн геологийн нэгдсэн судалгаа
- Эдийн засгийн судалгаа хийх, олон улсын зах зээлийн судалгаа хийх, "Монголын хөгжлийн судалгааны төв"-ийн чадавхийг бэхжүүлэх
- Гадаадын хөрөнгө оруулагч нарт зориулсан уул уурхайн салбарын мэдээлэл боловсруулах

- 3.12 Ашигт малтмалын газрын үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдэх ажлууд одоогоор ажлын даалгавар боловсруулах, зөвлөх сонгон шалгаруулах шатандаа байна. Үүнд:

- Ил далд уурхай боловсруулах болон баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох хууль боловсруулах
- Байгаль орчин нийгэмд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний зөвлөхийн үйлчилгээ
- Геологийн зураглалын стратеги болон мэдээллийн сан холбох, кадастрын онлайн мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх
- Хууль дүрэм журмын тухай сурталчилгаа хэлэлцүүлэг

- 3.13 “Ашигт малтмалын тухай” хууль шинэчлэгдэн батлагдсаны дараа зарим арга хэмжээ хэрэгжүүлэхээр байна. Ихэнх ажлын ХАА-ны төлөвлөгөө батлагдаагүй, хэрэгжих хугацаа тодорхойгүй байна.

Салбарын хөгжил, төрийн өмчийг удирдан зохицуулах, чадавхийг сайжруулах чиглэлээр явагдсан сургалтуудын үр дүн бага байна


- 3.14 “Уул уурхайн институцыг бэхжүүлэх техник туслалцаа”-ны төслийн хүрээнд 1,344.8 мянган ам.долларын зардлыг сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.
- 3.15 Дээрх зардлаар гадаадын улс орнуудад уул уурхайн салбарын чиглэлээр сургалт, семинар, туршлага судлах, танилцах аялал, дотоод сургалт семинарт холбогдох байгууллагуудын ажилтан албан хаагч нарыг хамруулсан байна. Тухайлбал:
- 2009 онд 29 хүн - 112.1 мянган ам.доллар
 - 2010 онд 110 хүн- 549.4 мянган ам.доллар
 - 2011 онд 80 хүн - 386.1 мянган ам.доллар
 - 2012 онд 33 хүн - 215.6 мянган ам.доллар
 - 2013 онд 18 хүн - 81.5 мянган ам.доллар
- 3.16 Дээрх үйл ажиллагаанд Ерөнхийлөгчийн зөвлөх, УИХ-ын гишүүд, Сангийн яам, ЭБЭХЯ, ЗТАЖЯ, БСШУЯ, ЭМЯ, АМГ, ТЕГ, УУХҮГ, ТӨХ, ҮХШХ, “Эрдэнэс МГЛ” ХХК, ШУТИС-ийн ажилтнууд хамрагдсан байна.
- 3.17 Зарим яам агентлагаас нэг хүнийг удаа дараа сургалтад явуулсан байна. Тухайлбал,
- ЭБЭХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын орлогч дарга С.Баярбат 7 удаа Австрали, Канад, Португали зэрэг улсад 34.3 мянган ам.доллар зарцуулж 2-3 удаа дараалан явсан;
 - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын орлогын хэлтсийн мэргэжилтэн Ж.Энхзул Австрали, Канад, АНУ-д 24.7 мянган ам.долларын зардлаар тус тус явжээ.
- 3.18 2011 онд дээрх яам, агентлагийн 203 хүнийг англи хэлний онлайн сургалтад хамруулснаас 77 хүн амжилттай суралцсан ч 126 хүн сургалтын сертификат авч чадаагүй байна.
- 3.19 Сургалтын нийт зардал 7.9 сая төгрөг бөгөөд English EZ боловсролын төв төсөл хэрэгжүүлэх нэгжийн хооронд хийсэн гэрээний 4.2-т амжилттай суралцагчдын төлбөрийг төсөл хэрэгжүүлэх нэгжээс, сертификат аваагүй суралцагч сургалтын төлбөрөө өөрөө хариуцна гэж заасан байна.
- 3.20 Суралцагсдын 63 хувь амжилтгүй төгссөн нь тухайн сургалтын програм ойлгомжгүй, зааврынхаа дагуу ажилладаггүй, ашиглалтын явцад алдаа зааж ашиглах боломжгүй болдог зэргээс шалтгаалсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, шинжилгээний дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✦ Хэлэлцээрт заасан төсөл хэрэгжүүлэх үндсэн хугацаа дууссан хэдий ч санхүүжилтийн 60.5 хувийг ашигласан, төслийн үндсэн зорилтын хэрэгжилт Сангийн яамны дүгнэлтээр 80 хүрэхгүй хувьтай байна.
- ✦ Төслийн удирдах хороог санхүүжилтийн хэлэлцээрт заасан бүрэлдэхүүнээр байгуулаагүй бөгөөд төслийн үйл ажиллагааг дэмжих, удирдлагаар хангах үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн байна.
- ✦ Төсөл хэрэгжүүлэх нэгжийн орон тооны бүтцийг журмын дагуу батлаагүй, батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаагаа санхүүжүүлээгүй байна.
- ✦ Төслүүдээс ихээхэн хэмжээний хөрөнгийг сургалт, танилцах аялалд зарцуулж буй боловч тэдгээрийн үр дүн, гүйцэтгэлийг тооцоогүй байна.
- ✦ Монгол Улсын Засгийн Газар болон Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын гэрээ болон Сангийн сайдын 2011 оны 86 дугаар журмыг нэг мөр даган хэрэгжүүлээгүй байна.

Сангийн яамнаас ирүүлсэн санал:


МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-02-47, <http://www.mol.gov.mn>

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР
ТАНАА

2013.10.01 № 4-2/5443
талбай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны саналаар "Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл", "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авлаа.

Тайлангийн төсөлтэй танилцаж, холбогдох заалтуудад хийх нэмэлт тайлбар, аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн авах арга хэмжээний зөвлөмжид оруулах саналуудыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 32 хуудастай.

САЙД  Ч.УЛААН

п. 3807

Сангийн сайдын 2013 оны
10 дугаар сарын 01-ны өдрийн
72/543 тоот албан бичгийн
хавсралт.

**НЭГ. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ
ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД
ӨГӨХ ТАЙЛБАР, САНАЛ**

Бүлэг 1. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төслийн удирдах хороо,
нэгжийн үйл ажиллагаа

ҮАГ-ын
тайлбар 1-ийг
үзнэ үү

2.3 Төслийн санхүүжилтийн гэрээнд ТУХ, ТХН-ийг байгуулж төслийн туршад байлгана гэсэн бөгөөд төслийг Дэлхийн банкны төслийн удирдагч, Төслийн захирал, Төслийн менежер удирдан ТУХ, ДБ-наас удирдлагын зааварчилгаа авч амжилттай хэрэгжүүлнэ гэж заасан. Үүний дагуу Сангийн сайдын 2009 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн тушаалаар байгуулагдсан ТУХ-ны бүрэлдэхүүнийг ажлын шаардлагын дагуу шинэчлэн сайжруулах зорилгоор нийт 4 удаа өөрчлөн, шинэчлэн байгуулсан байна. Аудитын тайланд хамрагдсан хугацаанд буюу 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн ТУХ-ны хурлаар ТУХ-ны бүрэлдэхүүнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оруулахаар шийдвэрлэсэн ба 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн Сангийн сайдын тушаалаар шинээр бий болсон яамд тухайлбал Эдийн засгийн хөгжлийн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны төлөөллийг оролцуулан төслийн зохицуулагчийг ТУХ-ны нарийн бичгийн даргаар ажиллуулахаар шинэчлэн байгуулсан болно.

/Хавсралт 1: ТУХ-ны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Сангийн сайдын тушаалууд, ТУХ-ны хурлын тогтоол /

ҮАГ-ын
тайлбар 2-ыг
үзнэ үү.

2.4, 2.5 Төслийн удирдах хороо Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журамд заасны дагуу тайланд хамрагдсан хугацаанд нийтдээ 17 удаа хуралдсан бөгөөд төслийн ерөнхий төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө, тайланг тухай бүр хэлэлцэж ирсэн. Хурлаар төслийн хэрэгжилтийг сайжруулах, удаашралыг арилгах талаар тодорхой арга хэмжээг тухай бүрд нь авах шийдвэр гаргаж ирснээр төслийн үр дүнг сайжруулах, төслийн хэрэгжилтийг түргэтгэхэд ихээхэн нөлөөлсөн.

ТУХ байгуулагдсан цагаасаа эхлэн Засгийн газрын хөгжлийн бодлогыг төслийн зорилго, зорилттой уялдуулан үйл ажиллагааны чиглэлд зөвлөгөө өгч, удирдлагаар хангаж, ерөнхий хяналт тавьж ажиллаж ирсэн. Жишээлбэл, Ерөнхий төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр заасан гар аргаар олборлох үйл ажиллагааг дэмжих багц ажлыг ДБ-тай зөвшилцөж төслөөс хасах шийдвэр гаргаж, төслийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, баталж ирсэн явдал болно.

Одоогоор ТУХ нь Төслийн санхүүжилтийн гэрээнд заасан төлөөллийг оролцуулсан бүрэлдэхүүнээр үүргийнхээ дагуу ТУХ-ны ажиллах журмын дагуу

ҮАГ-ын
тайлбар 3-ыг
үзнэ үү.

ажиллаж байгаа бөгөөд нийт 17 удаа албан ёсоор хуралдсанаас гадна ажлын журмаар ТУХ-ны гишүүд тулгамдсан асуудалтай танилцах байдлаар санал зөвлөгөө өгч ажиллаж байгаа болно.

/Хавсралт 2: 2009-2013 онд ТУХ хурал хуралдсан товъёор/

2.8, 2.9 Төслийн санхүүжилтийн хэлэлцээрт ТХН-ийг хамгийн багадаа үндсэн 3 ажилтантай байхаар заасны дагуу М.Энхбат, Д.Пүрэвсүрэн, Д.Туулыг зохих журмын дагуу сонгон шалгаруулж төслийн зохицуулагч, санхүүгийн мэргэжилтэн, худалдан авалтын мэргэжилтнээр тус тус томилон ажиллуулсан.

Мөн төслийн санхүүжилтийн гэрээнд "Худалдан авалтын төлөвлөгөө гэдэг нь хүлээн авагчийн 2008 оны 5 дугаар сарын 16-нд гаргасан төлөвлөгөөг хэлнэ" гэж хавсралтын 17-д заасан байдаг ба энэхүү худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан төслийн дагалдах ажилчид болох туслах худалдан авалтын мэргэжилтэн, төслийн туслах ажилтан, жолоочийг зохих журмын дагуу сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан.

/Хавсралт 3: ДБ-ны зөвшөөрөл Graeme Hancock, Төслийн ерөнхий төлөвлөгөө/

2010, 2011 онд төслийн үйл ажиллагаанд хийсэн Дэлхийн банк, Сангийн яамны хяналт, шалгалтын дүнд төслийн мониторинг, үнэлгээг сайжруулах, мөн төслийн талаарх мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлагатай талаар зөвлөмж гаргасан ба уг асуудлыг ТУХ-нд танилцуулах явцад төсөлд шаардлагатай тохиолдолд урт хугацааны зөвлөх /гадаад, дотоод/ авч ажиллуулах боломж байгааг онцлоод мониторинг, олон нийтийн харилцааны мэргэжилтэнг урт хугацааны зөвлөхөөр ажиллуулах санал дэвшүүлсний дагуу үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж сонгон шалгаруулалтаар 2011 оны 4 сараас эхлэн Ж.Цэгмидийг шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн дээрх тавигдсан шаардлагын дагуу төслөөс Австралийн хөгжлийн төлөөх сайн дурын хөтөлбөрт хүсэлт гаргасаны дагуу Тарек Дэйл сайн дурын ажилтанг төслийн мониторингийн үйл ажиллагаанд 2012-2013 онд ажиллуулсан.

/Хавсралт 4: ТУХ-ны тогтоол, 2011 оны төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө/

Бүлэг 2. Төслийн хэрэгжилт, үр дүн

ҮАГ-ын
тайлбар 4-ийг
үзнэ үү.

3.1 Төслийн хөгжлийн үндсэн зорилгын дагуу дунд шатны зорилтууд болон төслийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангах зорилгоор шаардлагатай зөвлөхийн ажлуудыг жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ирсэн ба төсөл эхэлснээс хойш 2012 оны 12 дугаар сарын байдлаар өргөн цар хүрээг хамарсан 26 зөвлөхийн үйлчилгээний гэрээг бүрэн санхүүжүүлээд байгаа болно.

Төсөл нь уул уурхайн салбарын бодлогын хүрээнд олон салбарыг хамран хэрэгжиж байгаа техникийн туслалцааны төсөл учир хэрэгжилтийн үр дүнг шууд харах боломжгүй онцлогтой хэдий ч төслөөс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн зарим ажлын үр дүнг дунд хугацааны зорилтын хүрээнд дурдаж болно. Үүнд:

1. Эдийн засгийн удирдан зохицуулах болон орлого цуглуулах гол байгууллагуудын үр ашиг дээшилсэн байна.
 - Улсын хөрөнгө оруулалтын санг байгуулах, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх зөвлөхийн үйлчилгээг зөвлөх Эрик Паррадоогоор хийлгэж гүйцэтгүүлэн зөвлөхийн тайланг Сангийн яаманд хүлээлгэн өгсөн ба тусгасан зөвлөмж саналыг хэлэлцэх олон улсын семинарыг Сангийн яам, Олон улсын валютын сантай хамтран зохион байгуулсан.
 - Татварын ерөнхий газрын Улсын төсвийн орлогын хяналтын газрын харьяанд Эрдэс баялгийн татварын алба байгуулахад тус төслийн зүгээс 2010 онд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн татварын хяналт шалгалт, аудит хийх талаарх сургалтыг зохион байгуулж, Татварын ерөнхий газрын мэргэжилтэн, ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлсэн бөгөөд тус алба нь хэвийн ажиллаж байна.
 - Төслийн зөвлөхүүд Монгол улсаас гадаад улс орнуудтай байгуулсан орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх хэлэлцээрийн зарим зүйл, заалтуудад харьцуулсан судалгаа хийж, боловсронгуй болгох санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэний дагуу гадаад улс орнуудтай байгуулсан давхар татварын гэрээнүүдэд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж эхэлсэн.
 - Олон улсын уул уурхайн татварын судалгаа хийх зөвлөхийн үйлчилгээг Татварын ерөнхий газарт хэрэгжүүлснээр уул уурхай, газрын тосны татварын хяналт шалгалт хийх аргачлалаар мэргэжилтнүүдийг сургаж чадавхижуулсан.
2. Олборлох үйлдвэрийн салбарын гол байгууллагуудын үр ашиг сайжирсан байна.
 - Эрдэс баялаг, эрчим хүчний яам болон Ашигт малтмалын газрын зүгээс кадастрын мэдээллийг багтаасан уурхайн кадастрын веб сайтыг хөгжүүлэх хүсэлтийн дагуу шинэ веб серверийг суурилуулж, мэдээллийн санг холбон ажиллуулж эхэлсэн. (ГАФАГ, Герман)
 - Уул уурхайн хаалтын олон улсын стандарт дүрэм журмыг судалж зөвлөмж өгөх үйлчилгээний хүрээнд хаалтын журмын төслийг боловсруулж Ашигт малтмал, Улсын мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн.
 - Уул уурхайн болон кадастрын онлайн мэдээллийн програм хангамж дээр ажиллах, лиценз олголт, дүрэм журмын талаарх сургалтуудад ажилтнуудыг хамруулж чадавхижуулсан.
3. Эрдэнэс МГЛ байгуулагдаж, удирдлага, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.
 - Шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамжаар хангасан.
 - Таван Толгойн ордод техникийн туслалцаа үзүүлэх зөвлөхийн үйлчилгээний үр дүнд Таван толгойн нүүрсний орд газрыг хуваан олборлох тооцоолол, үндэслэлийг боловсруулан Эрдэнэс МГЛ ХХК-д санал болгосон ба зөвлөхийн хамтран боловсруулсан Зүүн Цанхийн нүүрсний орд газрын техник эдийн засгийн үндэслэлийг Таван Толгойг хөгжүүлэх үндэслэл болгон ашиглаж байна.
 - Шивээ-Овоогийн төслийн санхүүгийн шинжилгээг зөвлөхийн зөвлөмжийн дагуу хамтран боловсруулсан.

- Ажилчдыг төслийн эдийн засгийн үнэлгээ хийх, уул техникийн олон улсын програм хангамж дээр ажиллаж сургасан.

ҮАГ-ын
тайлбар 5-ыг
үзнэ үү.

3.2 Мөн уул уурхайн хөрөнгө оруулалтын загвар гэрээг Эрдэнэс МГЛ ХХК-ийн жишээн дээр Хуульч эмэгтэйчүүдийн холбоо ТББ хийж гүйцэтгэсэн. Эрдэнэс МГЛ ХХК-ийн компанийн засаглалыг бий болгох зөвлөхийн ажлыг 2013 онд хийхээр төлөвлөсөн байгаа ба өмнө компанийн тогтолцоо, гэрээ байгуулахтай холбогдуулан хуулийн зөвлөх авч ажиллуулж байсан.

ҮАГ-ын
тайлбар 6-г
үзнэ үү.

3.4 Тус хэсэгт гар аргаар олборлох уурхай, жижиг уурхайн удирдлагыг боловсронгуй болгох 6 төрлийн дүрэм, журам гэж ташуу бичсэн байна. ТУХ-ны 2009 оны хуралдаанаар "гар аргаар олборлох уурхай, жижиг уурхайн удирдлагыг боловсронгуй болгох" ажлыг бусад төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж байгаа бөгөөд бодлогын хүрээнд төслийн ерөнхий төлөвлөгөөнд оруулах шаардлагагүй хэмээн үзэж уг ажлыг бүр мөсөн хассан.

ҮАГ-ын
тайлбар 7-г
үзнэ үү.

3.11-д дурдсан бүх ажлууд нь төслийн 2013 оны үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдан ба хэрэгжиж байгаа ба Гадаадын хөрөнгө оруулагч нарт зориулсан гарын авлагыг тайлант хугацаанд зөвлөхөөс хүлээн авч хэвлэн Уул уурхайн яаманд хүргүүлсэн болно.

ҮАГ-ын
тайлбар 8-ыг
үзнэ үү.

3.13 Ашигт малтмалын тухай хууль шинэчлэн батлагдсаны дараа зөвхөн хуулийг, холбогдох дүрэм журмын хамт таниулах, сурталчлах ажлыг хийхээр төлөвлөсөн.

ҮАГ-ын
тайлбар 9-ыг
үзнэ үү.

3.14-3.20 Төслийн нэг томоохон зорилт нь уул уурхайн салбарын хүрээнд төслөөс ашиг хүртэгч байгууллагуудын ажилтнуудыг сургах, чадавхийг бэхжүүлэх явдал бөгөөд үүний хүрээнд сургалт, семинар, хурал, чуулганд ажилчдыг хамруулсан. ТУХ-ны хурлаар сургалтын үр дүнг сайжруулах талаар хэд хэдэн удаа хэлэлцэж арга хэмжээ авч байсан бөгөөд үүний үр дүнд сургалтын төлөвлөгөөг урьдчилан баталж, сургалтанд хамрах мэргэжилтнүүдийн нэр, албан тушаалыг зөвхөн тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргын болон газрын даргын албан бичгээр, сургалтын зорилго болон хөтөлбөр, сургалтаас гарах үр дүнг авсны үндсэн дээр санхүүжүүлдэг, сургалтын талаарх тайланг тухайн байгууллага хүлээн авдаг процедурыг сайжруулсан. Сургалтад хамрагдсан ажилчдын тайланг ТХН хүлээн авч файлжуулахаас гадна тухайн байгууллагууд дотоод журмынхаа дагуу сургалтын тайланг хянаж ажиллаж байна. Англи хэлний сургалтын явц, төлбөрийн асуудлыг ТУХ-ны хурлуудаар хэлэлцэж шийдвэрлэсэн болно.

АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ЗӨВЛӨМЖИД ӨГӨХ САНАЛ

- Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай Сангийн сайдын тушаалыг шинэчлэн баталж, Засгийн газрын хэрэг зрхлэх газрын төлөөллийг бүрэлдэхүүнд нэмж оролцуулах
- Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дахин судалж, холбогдох өөрчлөлт оруулах, хэрэгжилт үр дүнг хянах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Харилцах дансны хүүгийн орлогыг холбогдох шийдвэр, батлагдсан төсөвгүй зарцуулсан холбогдох этгээдэд арга хэмжээ авах

Сангийн яамны саналд ҮАГ-аас өгөх тайлбар:

ҮАГ-ын тайлбар 1. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 2. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 3. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 4. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 5. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 6. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 7. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 8. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ҮАГ-ын тайлбар 9. Өөрчлөлт оруулах шаардлагагүй.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Сангийн сайд Ч.Улаанд

- ✦ Төслийн удирдах хороог Эдийн засгийн хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан байгуулах,
- ✦ Төслийн хэрэгжилт, тусламж, зээлийн хөрөнгөний ашиглалтыг сайжруулахад анхаарч, үр дүн гарахуйц, нэн шаардлагатай үйл ажиллагаанд зарцуулах,
- ✦ Төслийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тооцох, ажлын тайлан гүйцэтгэлийг гаргуулан авч байх,
- ✦ Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Монгол Улсын Засгийн газар, ОУХА хооронд байгуулсан гэрээ, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар журмын дагуу байгуулж, ажиллуулах,
- ✦ Харилцах дансны хүүгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулж, холбогдох этгээдэд арга хэмжээ авах,



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх болон Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслүүдийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн Яаманд хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2014 оны 03 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал (Б.Баттуяа)-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070497